



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Эрдмийн их сургууль

Хөтөлбөрийн нэр: Бизнесийн удирдлага

Индекс: E04130101

Шинжээчийн баг:

Ахлагч: Б. Даваасүрэн

Гишүүд: Д.Батжаргал

Б. Болормаа

2020.06.02

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- БУМ - Бизнесийн удирдлагын магистр
- БМИҮЗ - Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
- МУЭИС - Монгол улсын Эрдмийн их сургууль
- БУС - Бизнесийн удирдлагын сургууль
- БУ - Бизнесийн удирдлага
- БУПБ - Бизнесийн удирдлагын профессорын баг
- ӨҮБ - Өөрийн үнэлгээний баг
- ӨҮТ - Өөрийн үнэлгээний тайлан
- СБЗГ - Сургалтын бодлого, зохицуулалтын газар
- PDCA - ISO Чанарын удирдлагын зарчмууд
- УМС - Удирдлагын мэдээллийн систем

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол улсын Эрдмийн их сургууль, Бизнесийн эрдмийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Бизнесийн удирдлага	
Индекс	E04130101	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> Б. Даваасүрэн Улаанбаатар Эрдэм их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал Д.Батжаргал СЭЗИС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, Хамтын ажиллагаа, бизнес хөгжлийн хүрээлэнгийн захирал Б.Болормаа Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн 	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Г. Даваажаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	2020.02.12	Өөрийн үнэлгээний тайланг авч, танилцан урьдчилсан үнэлгээний тайланг гаргах
	2020.05/21-22	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2020.05/29	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020.05/29	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2020.06/02	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020.06/03	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн дүрэм, Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол улсын Эрдмийн их сургууль нь ахисан түвшний сургалт, судалгаа явуулдаг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн байгууллага юм. Тус сургууль өнөөдрийн байдлаар 10 мэргэжлээр докторын, 17 мэргэжлээр магистрын сургалт зохион байгуулж байна. Боловсрол судлал, Гадаад хэл шинжлэл магистрын сургалтын хөтөлбөрийг 2014 онд магадлан итгэмжлүүлсэн. 2019-2020 оны хичээлийн жилд /E04130101/ Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-өөр магадлан итгэмжлүүлэх зорилт тавьж, энэ хүрээнд тус сургуулийн захирлын 2019 оны 2-р сарын 25-ны 20 тоот тушаалаар өөрийн үнэлгээний баг байгуулж, өөрийн үнэлгээний тайлангаа бэлтгэсэн.

Тус сургууль Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрийг 2003 оноос хэрэгжүүлсэн бөгөөд энэ хугацаанд Монгол Улсын ба гадаадын 2040 гаруй иргэд суралцаж төгссөн байна. Уг хөтөлбөр нь судлаач магистр ба мэргэшсэн магистр гэсэн 2 төрөлжилттэй байгаа бөгөөд мэргэшсэн магистр нь 32 кредитийн, судлаач магистр нь 30 кредитийн агуулгын багтаамжаар сургаж байна. Хөтөлбөрийн агуулгад сонгон судлах хичээлийн эзлэх хувийн жин 80 хувь байгаа нь түүний нээлттэй, нийгмийн эрэлт хэрэгцээнд дасан зохицох чанар өндөр байгааг харуулж байна.

Хөтөлбөрийн сайжруулалт, шинэчлэлтийг сүүлийн 5 жилд 3 удаа үе шаттай хийсэн нь шинэчлэлийн үйл явц сайн байгааг илтгэж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбогдсон судалгааны материал
- Хурлын тэмдэглэлүүд
- Шинжээчдийн хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн нийгэм эдийн засаг, технологийн орчин болон зах зээлийн эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ иж бүрэн хийгдсэн байдал
- Гадаад дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан бенчмаркинг
- Хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн судалгаа /Ажил олгогч, төгсөгч, суралцагч , багш /

Анхаарах асуудал:

- Магадлагдаж байгаа хөтөлбөрөөр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг улам нарийвчлах, хэд хэдэн жилийн динамикаар хийж харуулж байх, мөшгих судалгааны арга хэлбэрийг сайжруулах.
- Хийгдэж байгаа судалгааны баримтжуулалт, сургалтын ажилд тусгах арга хэлбэрт анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хариуцан явуулж байгаа сургууль, профессорын баг хөтөлбөрийн талаар судалгааны материалыг бүрдүүлэх, үр дүнд нь дүн шинжилгээ хийж хэвших.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Батлагдсан хөтөлбөр, түүнийг дагалдах судалгааны материал
- 2018.09.10-ны профессорын багийн хурлын протокол
- 2018.09.27-ны өдрийн Хөтөлбөрийн хорооны хурлын протокол
- 2019.01.10, 2019.01.24 өдрийн багийн болон хөтөлбөрийн хорооны хурлын протокол
- Шинжээчдийн суралцагч, төгсөгчидтэй хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилгыг сургуулийн хөгжлийн алсын хараа, БУС-ийн эрхэм зорилготой уялдуулан уялдаа логик сайтай тодорхойлсон.
- Хөтөлбөрийн хувьд онцлог зорилгын мод боловсруулсан.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнгүүдтэй холбож сургалтын баримт бичигтээ тусган төлөвлөсөн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явц, ялангуяа магадлан итгэмжлэлийн тайланг сонирхогч бүх талуудад мэдээлэх үндсэн дээр олон нийтийн оролцоо, эргэх холбоог хангах тал дээр анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн шинэчлэлийг багшлах бүрэлдэхүүний жигд оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Батлагдсан хөтөлбөр, түүнийг дагалдах судалгааны материал
- Сургалтын болон хичээлийн хөтөлбрүүдийг хэлэлцэн баталсан хурлын тэмдэглэлүүд
- 2018.09.10-ны профессорын багийн хурлын протокол
- 2018.09.27-ны өдрийн Хөтөлбөрийн хорооны хурлын протокол
- 2019.01.10, 2019.01.24 өдрийн багийн болон хөтөлбөрийн хорооны хурлын протокол
- Шинжээчдийн хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын хөтөлбөрийг судлаач/ 30 кр/ болон мэргэшсэн/ 32 кр / гэсэн агуулгын багтаамжтайгаар төрөлжүүлэн боловсруулж хэвшсэн.
- Судлаач магистрын хувьд ЭША, төгсөлтийн ажилд илүү түлхүү , харин мэргэшсэн магистрт чадвар , дадал олгоход түлхүү анхаарах бодлогыг хэрэгжүүлдэг болсон.
- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдийн өнөөгийн хэрэгжилтийн байдалд SWOT болон TOWS шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл байдлаа оношилсон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцыг тухай бүр баримтжуулан, албажуулж нийтэд хүртээмжтэй хэлбэрээр ашиглахад анхаарах.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Судалгааны материал
- Хурлын тэмдэглэлүүд
- 2018.09.10-ны профессорын багийн хурлын протокол
- 2018.09.27-ны өдрийн Хөтөлбөрийн хорооны хурлын протокол
- 2019.01.10, 2019.01.24 өдрийн багийн болон хөтөлбөрийн хорооны хурлын протокол
- Шинжээчдийн багш, суралцагчид, төгсөгчидтэй хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Тус хөтөлбөрийн шинэчлэлийг 3 жил дараалан хийж бэлтгэл хангасан.
- Хөтөлбөрийн шинэчлэлийг арга зүйн үндэслэл сайтай, Блумийн таксономи, хандлагын ба үйлийн таксономи, ЮНЕСКО-ийн тогтвортой байдлын 8 чадамж зэрэг тулгуурлан боловсруулсан.
- Суралцагчийн ачааллыг нэг улиралд 9-12 кредит байхаар үндэслэлтэй тодорхойлж хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийн ба хичээлийн уялдааг хангалттай сайн гаргаж, хөтөлбөрийн модоор баталгаажуулсан
- Цахим бизнес, интрепренершип, ногоон бизнес гэх мэт ирээдүйд чиглэсэн хичээлийн хөтөлбөрүүдийг бий болгож , сургалтандаа нэвтрүүлсэн.

Анхаарах асуудал:

- Шинэчилсэн хөтөлбөрийг туршин нэвтрүүлж байгаа хугацаа харьцангуй бага учраас үйл явцын хяналт мониторинг, тасралтгүй сайжруулалтад анхаарах.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нарын хамтын ажиллагаа, дотоод уялдааг сайжруулахад түлхүү анхаарах.

- Хөтөлбөрийн үр шимийг хүртэгч үндсэн 3 хэрэглэгчийнхээ эрэмбэлэгдсэн хэрэгцээ шаардлагад чиглүүлэн зорилго, зорилтоо нарийвчлан тодорхойлж, сайжруулах арга замаа сонгон хэрэгжүүлэх.
- Уг хөтөлбөрийг сонирхогч талуудтай хамтран хэрэгжүүлэх ажлаа өргөжүүлэх.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Судалгааны материал
- Хурлын тэмдэглэлүүд
- Шинжээчдийн багш, суралцагчид, төгсөгчидтэй хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүйг танхимын, зайн, онлайн технологиудыг хослон хэрэгжүүлдэг.
- Сургалтын үйл явцын удирдлага, онлайн сургалтад хиймэл оюуныг ашиглах эхлэл тавигдсан. Мобайл аппликейшн ашиглан, оюутан бүр зайнаас багштай шууд харьцах хөдөлгөөнт зайн сургалтын технологийг туршиж байна.
- Сургалтын арга зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтэд зохих түвшинд судалгаа, дүгнэлт хийсэн.

Анхаарах асуудал:

- Багш, сургалт заах арга зүйн чадварыг голлон санал асуулгад тулгуурлан дүгнэж байгааг олон төрлийн судалгаанд тулгуурладаг, багшийн албан тушаалын шатлалаар ялгавартай болгоход анхаарах.

Зөвлөмж:

- Сургалтын арга зүй, технологийн шинэчлэлтэй уялдуулан ахмад, туршлагатай багш болон залуу багш нарын уялдаа холбоог сайжруулах, технологийн шинэчлэлийг тогтвортой авч явах залгамж холбоо, ирээдүйн боловсон хүчнээ бэлтгэх бодлого, тогтолцоотой болох.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Холбогдох журам , заавар
- Багшийн журнал, үнэлгээ хийсэн материал, судалгааны материал
- Шинжээчдийн багш, суралцагчид, төгсөгчидтэй хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч төвтэй үнэлгээний арга зүйг суралцахуйн үр дүнтэй холбон боловсруулж нэвтрүүлсэн.
- Суралцагчдын сурлагын үр дүнг нэгтгэн тооцдог статистик судалгаа хэрэгжиж чадсан.

Анхаарах асуудал:

- Сургалтын үр дүнг хичээл, багш бүрээр болон оюутан бүрээр суралцсан үр дүнгийн өөрчлөлтийг гаргасан тодорхой судалгаануудыг хийж, үр дүнг сургалт арга зүйн үйл ажиллагааны сайжруулалтандаа ашигладаг байх.
- Сургалтын технологийн өөрчлөлттэй уялдуулан суралцагчдыг үнэлэх журам заавраа шинэчлэх.

Зөвлөмж:

- Үр дүнд чиглэсэн сургалтын тогтолцоо нэвтрүүлэх чиглэлд суралцагчдын үнэлгээнд тэдний чадвар, дадалд гарч байгаа өөрчлөлтийг үнэлэх боломжийг цаашид өргөжүүлэхэд анхаарах.
- Суралцагчийн үнэлгээнд мэдээллийн технологийн боломжийг илүү өргөн хүрээтэй ашиглах, энэ чиглэлд сургалтын удирдлагын мэдээллийн системийн хөгжил шинэчлэлийг чиглүүлэх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургуулийн орчинтой биечлэн танилцсан байдал
- ӨҮ-ний багийн танилцуулга , PPT
- Холбогдох судалгааны материал
- Шинжээчдийн ажлын уулзалтуудын тэмдэглэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- УБ хотын төвд 15 давхар, 7364,9м² , сургалтын зориулалттай Эко барилгатай.
- Сургалтын төрөлжсөн заал, номын сан, танхмууд болон хиймэл оюун ухааны лабораторитай.

- Ахисан түвшний оюутны амьдралын орчныг өнөөгийн стандарт түвшинд хангах нөхцөл бүхий оюутны дотуур байртай.
- Хөтөлбөрт холбогдох сургалтын цогц хэрэглэгдэхүүн, аргачлал, журам, заавар

Анхаарах асуудал:

- Ахисан түвшний оюутнууд бие дааж ажиллах орчныг бүрдүүлэхэд цаашид тасралтгүй анхаарах.

Зөвлөмж:

- Хиймэл оюун ухааны лабораторийн үйл ажиллагааг бүх талаар дэмжих
- Тус хөтөлбөрөөр гадаад оюутнууд олноор суралцах хандлага байгаатай уялдуулан оюутны байрын стандартыг улам сайжруулах, байрандаа бие даан суралцах орчин нөхцөлийг улам сайн бүрдүүлэх.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургуулийн орчинтой биечлэн танилцсан байдал
- ӨҮ-ний багийн танилцуулга , PPT
- Холбогдох судалгааны материал
- Шинжээчдийн уулзалтуудын тэмдэглэл
- Сургуулийн УМС /[https:// gradedu-855be.web.app/](https://gradedu-855be.web.app/)
- Сургуулийн вебсайт, фейсбуук

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ахисан түвшний оюутны суралцах үйл явцыг хөтлөх, дэмжлэг үзүүлэх магистрант, докторантын ном боловсруулж ашиглаж байна.
- Ахисан түвшний сургалтыг зохион байгуулахад шаардлагатай удирдамжийн шинжтэй журам, заавруудаар үндсэндээ хангагдсан байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын хэрэглэгдэхүүний хангамж, хүрэлцээний байдлыг сэтгэл ханамжийн судалгаанд илүү тодорхой тусгах.
- E контент хэлбэрт боловсруулсан материал хөтөлбөрийн орчин үеийн хэрэгцээг бүрэн дүүрэн хангахгүй байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Хичээлийн хөтөлбөрүүдийн боловсруулалтыг сайжруулах, хөтөлбөрт орсон шинэ хичээлүүдэд онцлон анхаарах.

- Хөтөлбрөөр суралцаж байгаа ахисан түвшний оюутнуудын хэрэгцээ шаардлагыг хангахуйц орчин, үйл ажиллагааны горим бүхий бие даалтын төвүүдийг тогтвортой ажиллуулдаг болох.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургуулийн орчинтой биечлэн танилцсан байдал
- ӨҮ-ний багийн танилцуулга, РРТ, шинжээчдэд зориулан бэлтгэсэн материал
- Номын санд холбогдох судалгааны материал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОХУ-ын ерөнхийлөгч Б.Ельциний нэрэмжит цахим номын сан
- Хэвлэмэл бүтээгдэхүүн 8350 ширхэг, Дисс. 225 ширхэг, Магистрын төгсөлтийн ажил 1430 ширхэг болон нэлээд олон тоотой цахим эх сурвалжууд бүхий орчин үеийн номын сан

Анхаарах асуудал:

- Номын фондын төрөлжилт, хөтөлбөрийн байнга өөрчлөгдөж байгаа сургалтын шинэ хэрэгцээг хангах байдалд судалгаатай байх, шинэчлэлийг эрчимжүүлэх
- Е- номын санг хөгжүүлэх, хөтөлбрөөр суралцагч оюутнууд нээлттэй эх сурвалжуудыг ашиглах орчинг бүрдүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- БНХАУ-аас суралцдаг оюутнуудыг шаардлагатай ном эх сурвалжаар хангах бодлого зохицуулалтад түлхүү анхаарах.
- Онлайн сургалтын хэрэгцээ нэмэгдэх хандлагатай уялдуулан энэ чиглэлд тодорхой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбогдсон судалгааны материал
- БУП багийн их семинарын протокол, хурлын тэмдэглэлүүд
- 2017 оны 12 сарын 13, 2018 оны 01 сарын 10, 23-ний өдрийн протокол, ирцийн бүртгэл
- БУМ-ын хөтөлбөрт хамаарах өргөдлүүд
- МУЭИС-ийн УЗ, Эрдмийн зөвлөл, Захиргааны зөвлөлийн 2016 оны 09 сарын 09-ний хамтарсан хурлаар баталсан МУЭИС-ийн 2016-2026 оны стратеги төлөвлөгөө
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- МУЭИС нь “Онлайн хичээл бичлэгийн лаборатори” төсөл хэрэгжүүлж, гар утасны аппликейнаа ашиглан утсан дээрээсээ видео хичээлүүдэд хамрагдах боломжийг оюутнуудад олгосон нь онцлог бөгөөд давуу талтай болжээ. Ялангуяа COVID-19 цар тахлын нөхцөлтэй холбоотойгоор сургалтын арга хэлбэрт өөрчлөлт оруулж, мобайл сургалтыг амжилттай хөгжүүлж байгаа нь дээд боловсролын бусад байгууллагуудын хувьд туршлага болно гэж үзлээ.
- 2019 оноос УМС-ээ шинэчилж <https://gradedu-855be.web.app/> ашиглаж байна, уг системээр багшийн үйл ажиллагааг хянах болон сургах явцын талаар дүн шинжилгээ хийж, системийн үр дүнг үнэлэх боломж бүрдсэн.

Анхаарах асуудал:

- БУМ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой мөрдөж байгаа бодлогын болон эрх зүйн 13 дүрэм, журамд 2017 оноос хойш ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт ороогүй байгааг анхаарч, шинэчлэх..
- Сургуулийн веб сайтаа тогтмол шинэчлэх, хөтөлбөрийн мэдээллээ тодорхой оруулах
- Профессорын багийн их семинарт хамрагдсан БУМ-ын хөтөлбөрийн магистрантуудын ирцийн бүртгэлийг хийж хэвших.

Зөвлөмж:

- Сургуулийн хэмжээнд хийгдэж байгаа аливаа судалгаа, гүйцэтгэсэн ажил, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт-мониторинг хийж, шинэчлэх.
- Багш, оюутнуудын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Төслийн ажлын гэрээ, хэлцэл

- ОХУ-ын Санкт-Петербургийн МТМОСҮИС, ОХУ-ын “Центр Информ” ТӨҮҮГ, ОХУ, Тайванийн “Сетевой технологий” ХНН, “Монгол өмгөөлөгч” хууль зүйн фирм (2016), Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо (2017)-той байгуулсан гэрээ
- ZhongHong олон улсын шинжлэх ухаан, технологи, инновацын хүрээлэнтэй 2019 оны 8 дугаар сард байгуулсан хамтын ажиллагааны гэрээ
- Сургалтын үйл ажиллагааны талаарх 2017, 2018 онд явуулсан судалгаа
- Захирлын 2017-2019 оны тушаал
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

БНХАУ-ын Бээжин хотод МУЭИС албан ёсны оффисоо нээснээр судлаач профессоруудыг солилцох боломжийг бүрдүүлээд байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын үйл ажиллагааны талаарх 2017, 2018 онд явуулсан судалгааны үр дүнгийн мөрөөр талаар авч хэрэгжүүлж байгаа ажлуудаа тодорхой тайлагнаж хэвших.
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах, судалгаа шинжилгээний ажлыг дэмжих үйл ажиллагааг улам эрчимжүүлэх.

Зөвлөмж:

- Дотоод, гадаадын судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай хамтарсан төсөл хөтөлбөрийн гэрээ хэлцэл, хэрэгжилтийн тайлан, төслийн үр дүнгийн талаар гэрээ дүгнэсэн акт зэргийг тогтмол үйлдэж, архивлах, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөх.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- БУМ-ын хөтөлбөрийн 2015-2019 оны төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БУМ-ийн хөтөлбөрийн үйл ажиллагааг сайжруулах, түүнд зориулагдсан зардлыг нэмэгдүүлэх 2019-2022 оны дунд хугацааны төлөвлөгөө гарган, төсөвлөх ажил зөвхөн судалгааны шатанд явж байна.

Анхаарах асуудал:

- БУМ-ын хөтөлбөрийн орлого 2015-2018 онуудад буурч, зардал өссөн бөгөөд нэг суралцагчид ногдох өртөг зардал 500 мянгаас 1,500 мянган төгрөг хүртэл өссөн байх тул өртөгт эзлэх үйлчилгээний чанарыг сайжруулах зардлыг нэмэгдүүлэхэд анхаарах.

- Магистрын нийт 17 хөтөлбөр хэрэгжүүлж байгаагаас БУМ-ийн хөтөлбөр нь санхүүгийн үр ашгийн хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй буюу 2018, 2019 онд төсөвлөснөөр 82,9 сая төгрөг, 33 сая төгрөгийн; нийт үр дүнд эзлэх хувиар 53%, 24%-тай байна. Багш нарыг мэргэжил, мэдлэгээ сайжруулахад зориулан төсөвлөсөн төсөв бага, тухайлбал, 2018, 2019 онд төсөвлөснөөр нийт хөтөлбөрийн зардлын 4,4%, 5,6%-ийг эрдэм шинжилгээний зардал эзэлж байна.
- БУМ-ын хөтөлбөрийн төсөв, санхүүгийн үр дүнг бодитой тооцож чадахгүй байгааг анхаарах.

Зөвлөмж:

- БУМ-ийн хөтөлбөрт зориулагдсан төсөв, зардлыг нэмэгдүүлэх, эсхүл байгаа нөөцөө үр ашигтай зарцуулах шаардлагатай. Үүний тулд, хөтөлбөрт суурилсан төсөв зохиох, санхүүгийн болон санхүүгийн бус үр дүнг хөтөлбөрт суурилж тайлагнадаг байх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
- Эрдэм шинжилгээний зардлыг нэмэгдүүлэх, гадаад, дотоод сургалт, хурал семинарт хамрагдах багш нарын оролцоог тэгш хангах.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- 2017-2019 оны маркетингийн төлөвлөгөө
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага
- Сургуулийн УМС / [https:// gradedu-855be.web.app/](https://gradedu-855be.web.app/)
- Сургуулийн вебсайт, фейсбуук

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Анхаарах асуудал:

- БУМ-ын хөтөлбөрийн 2017-2019 оны маркетингийн төлөвлөгөөг хэрэгжүүлж дууссан боловч үр дүнг үнэлэх ажил хийгдээгүй.

Зөвлөмж:

- БУМ-ын хөтөлбөрийн 2017-2019 оны маркетингийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашдын чиг хандлагыг тодорхойлох

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургуулийн веб хуудас, танилцуулга материал, эрдэм шинжилгээний бүтээл, самбар
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

- Сургуулийн фейсбуук, оюутны емейл хаяг, УМС

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БУМ-ын хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд ил тод мэдээллийг хүргэж хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Сургуулийн веб хуудсанд тавьсан мэдээллүүд хуучирсан байгааг анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Олон нийтэд хүргэж байгаа мэдээллийг тогтмол шинэчилдэг байх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургуулийн веб хуудас
- МУЭИС-ийн захирлын 2016.8.11-ний 04 тоот тушаалын 02 дугаар хавсралтаар батлагдсан “МУЭИС-ийн магистр, докторын сургалтын журам”
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

- **Онцлог зүйл/Туршлага:** “МУЭИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын дагуу элсэгчдийг элсүүлэн авч хэвшсэн. Сүүлийн 5 жилд нийтдээ 543 магистрант суралцсан ба үүнээс гадаад оюутан 3 (БНХАУ) байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургалтын үйл ажиллагааны талаарх 2017, 2018 онд явуулсан судалгааны тайлан
- 2017, 2018, 2019 оны “Магистрантын ном”, магистрын сургалтын хуанли
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Шинэ элсэгчдэд шаардлагатай бүхий л мэдээллийг багтаасан, баримжаа олгох ач холбогдолтой магистрын сургалтын хуанли ашигладаг.
- БУМ-ын сургалтын хөтөлбөрт “Байгууллагын соёл”, “Байгууллагын мэдээллийн удирдлага, хиймэл оюун ухаан”, “Ногоон бизнес” гэсэн хичээлүүд багтдаг онцлогтой.
- БУМ-ын хөтөлбөрийг төгсөгчдийн сэтгэл ханамж 2017-2019 онуудад 3,92-оос 4,49; магистрантын сэтгэл ханамж 3,90-ээс 4,21; ажил олгогчдын сэтгэл ханамж 3,75-аас 4,14 болж нэмэгдсэн байна.
- Ажил олгогч, төгсөгчидтэй 2020 оны 5 дугаар сарын 22-нд хийсэн уулзалтаас харахад, МУЭИС-ийн БУМ-ын хөтөлбөр төгссөн төгсөгчид нь давхар гадаад хэлний мэдлэгтэй төгсдөг учир ажилд авахад илүү давуу талтай гэж ажил олгогчдын зүгээс онцлон үнэлдэг.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайлангийн 44-р хүснэгтэд дурдагдсан магистрантуудад зориулсан эрдэм шинжилгээний арга хэмжээнүүдийн оролцоог харахад эрдэм шинжилгээний хуралд оролцогчдын тоо сүүлийн 5 жилийн байдлаар 15-аас 3 болтлоо буурсан байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Магистрантуудын дунд зохион байгуулдаг хэлэлцүүлэг, мэтгэлцээнээ өргөжүүлэх замаар-онолын мэдлэгийг практик хэрэглээтэй уялдуулах..
- Судалгааны их сургуулийн хувьд эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Сургуулийн веб хуудас
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн оюутны зөвлөлөөс зохион байгуулдаг спортын өдөрлөгт магистрантууд идэвхтэй оролцдог, “Шилдэг оюутан”, “Шилдэг судлаач оюутан” өргөмжлөл, захирлын нэрэмжит тэтгэлэг олгодог байна.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр магистрантууд нь өдрийн сургалтаас онцлогтой ч гэсэн тэдгээрийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал, цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл, олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон

суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл дутмаг байгаа нь энэ чиглэлд бага анхаарч байна уу гэсэн дүгнэлтэнд хүргэж байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Магистрантуудыг сайн дурын, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог идэвхжүүлэх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- МУЭИС-ийн захирлын 2016.8.11-ний 04 тоот тушаалын 02 дугаар хавсралтаар батлагдсан “МУЭИС-ийн магистр, докторын сургалтын журам”
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

МУЭИС-д шилжин ирсэн магистрантуудад 10 багц цагаас илүү дүйцүүлэлт хийхгүй байгаа нь суралцагчийн эрх ашгийг бодолцсон, хөтөлбрийн хувьд харьцангуй нээлттэй бодлого явуулдаг.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- МУЭИС-ийн захирлын 2016.8.11-ний 04 тоот тушаалын 02 дугаар хавсралтаар батлагдсан “МУЭИС-ийн магистр, докторын сургалтын журам”
- Хурлын тэмдэглэл
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн баримт бичиг, түүнийг олгох дүрэм журам иж бүрэн боловсруулагдсан.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн шинэчлэлийн багштай холбогдсон судалгааны материал
- Хурлын тэмдэглэлүүд
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн сонгон шалгаруулалт, ажлын үнэлгээ, урамшууллын журмаа тодорхойлсон багшийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх профессорынын баг, Бизнесийн сургуулийн эрдмийн зэрэг, цолтой багш нарын хувийн жин боломжийн өндөр
- Үндэсний тэргүүлэх эрдэмтдийг профессорын багтаа татан оролцуулах талаар идэвхтэй ажилладаг, уг чиглэлд өөрийн гэсэн арга хэлбрүүдийг үр дүнтэй ашиглаж чадаж байгаа

Анхаарах асуудал:

- Багш нарын хөдөлмөрийн үйл ажиллагааг улам бүр ил тод, шударгаар үнэлж, урамшуулахад анхаарах.

Зөвлөмж:

- Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа зөвлөгөө өгөх цахим талбараа хөгжүүлэх.
- Энэ хөгжлийн үйл явцдаа тулгуурлан багшийн хөдөлмөрийн гүйцэтгэлийг үнэлэх бүртгэх тогтолцоогоо сайжруулж, түүнийгээ цалин урамшуулалттай нь улам нягт холбох.
- Ахисан түвшний их сургууль болохын хувьд бусад их сургуульдтай бүх талаар хамтын ажиллагаа, хоршилтоо улам гүнзгийрүүлэх.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн шинэчлэлийн багтай холбогдсон судалгааны материал
- Багшийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд / Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөр, карьер хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө/
- Хурлын тэмдэглэлүүд
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: : Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн бодлогын иж бүрэн баримт бичигтэй.
- Үндэсний хэмжээнд үнэлэгддэг шилдэг профессоруудаар залуу багш, ахисан түвшний оюутнууддаа орчин үеийн хамгийн тулгамдсан асуудлаар лекц тогтмол уншуулдаг, мөн уулзалт ярилцлага, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулдаг.
- Багшийн хөгжилд гадаад харилцааны боломжоо сайн ашигладаг.

Анхаарах асуудал:

- Тус сургуулийн ахисан түвшний сургалтын үйл ажиллагаа ахмад, туршлагатай, нэр хүндтэй профессоруудад илүүтэй тулгуурладаг учраас ахмад залуу үеийн залгамж холбоог хангах хүний нөөцийн хөгжлийн бодлогодоо онцгой анхаарах.

Зөвлөмж:

- Сургуулийн удирдлагаас ахмад, залуу үеийн багш нарын зохистой тэнцвэрийг хангасан, тогтвортой хөгжлийн хүний нөөцийн бодлого явуулах.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн шинэчлэлийн багштай холбогдсон судалгааны материал
- Хурлын тэмдэглэлүүд
- Шинжээчдийн хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: : Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх профессорын баг, Бизнесийн сургууль нь эрдмийн зэрэг , цолтой багш нарынхаа өндөр хувийн жинд тулгуурлан олон салбарын огтлолцлыг хамарсан судалгааны ажил хэрэгжүүлэх боломжтой.
- Эрдмийн сургуулийн онцлог төрөлжилттэй уялдан БУ-ын хөтөлбөрт оролцогч багш нар үндэсний аюулгүй байдал, олон улсын харилцаа болон үндэсний үнэт зүйлсийг хамарсан өргөн хүрээний судалгаа явуулах, төслийн судалгааны ажил олох боломж нөхцөлтэй, энэ чиглэлдээ ч багагүй үр дүнд хүрч байгаа

Анхаарах асуудал:

- Хэрэгжүүлж ирсэн судалгааны төслүүд хувь хүн, тухайн профессорын төрөлжсөн чиглэлтэй л холбогдож ирсэн нь магадлан итгэмжлэгдэж байгаа хөтөлбөртэй уялдаагүй, зорилтот үр дүн багатай байх хандлагатай явж ирснийг анхаарах.

Зөвлөмж:

- БУ-ын сургууль, профессорын баг судалгааны төсөл хэрэгжүүлэх, тендер шалгаруулалтад тогтмол оролцдог байх.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн шинэчлэлийн багштай холбогдсон судалгааны материал
- Багш нарыг үнэлэх журам, заавар
- Хурлын тэмдэглэлүүд
- Шинжээчдийн хийсэн уулзалт , ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

Багшийн үнэлгээг хэрэгжүүлж байгаа байдал нь бусдаас ялгарах онцлог бага, ерөнхийдөө стандарт буюу нийт сургуулиудын жишиг түвшинд байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт хамрагдах багш нарын дийлэнх хэсэг гэрээгээр ажилладаг, цөөн хүн үндсэн орон тоонд ажилладаг байдал нь багш нарын ажлын үнэлгээний өвөрмөц нөхцөлийг бүрдүүлж байгаа, ялангуяа сургалтын ажлын зарим асуудалд гэрээт багш нарын ажлын үнэлгээнд сургуулиас нөлөөлөх боломж муу байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр суралцагчдыг бие даалган суралцуулах үйл явцыг тасралтгүй удирдах багшийн үйл ажиллагааны үр дүн, үр өгөөжийг сайжруулах хяналт урамшууллын тогтолцоогоо сайжруулах.
- Үүнтэй уялдан сургалтад цахим талбарыг илүү өргөн ашиглах, багш нарыг уг чиглэлээр ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлэх.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: : Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- 2017 онд байгууллагын магадланд орсон ӨҮТ
- Хөтөлбөрийн дэд хороо, БУС-ын болон Эрдмийн их сургуулийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлын материал

- Төгсөгчид, ажил олгогчдоос авсан санал асуулгын судалгаа
- Шинжээчдийн хийсэн уулзалт , ярилцлагууд

Шалгуурыг хангасан байдал: : Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 оны захирлын Б/500 тушаалаар СБЗГазрын дэргэд Чанарын баталгаажуулалтын хэлтэс байгуулсан.
- Дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын механизмыг ашиглан олон улсын чанарын стандартын PDCA суурь зарчимд тулгуурлан хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийн дэд хороо, бүрэлдэхүүн сургуулийн хороо болон Эрдмийн их сургуулийн ерөнхий хороо гэсэн шатлалаар хөтөлбөрийг баталгаажуулдаг тогтолцоог үндсэнд нь хэвшүүлсэн.
- Чанарын баталгаажуулалтын журамтайгаас гадна түүнийгээ хэрэгжүүлэх заавар боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн дотоод баталгаажуулалтыг хөндлөнгөөс баталгаажуулах үйл явцыг эрчимжүүлэх, зөвхөн дотоодын төдийгүй олон улсын түвшний баталгаажуулалтад ойрын жилүүдэд төлөвлөж орох.

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажуулалтын хэлтэс сургалтын албаны бүтцэд байх нь зохимжгүй бөгөөд сургуулийн захирлын удирдах чиг үүргийн хүрээнд байвал дотоод хөндлөнгийн хяналтыг гүйцэтгэх боломжтой.
- Хөтөлбөрийн эргэх холбоог тодруулахад цахим технологи ашиглах үйл явцаа эрчимжүүлэх.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Чанарын хяналт баталгаажуулалтын төлөвлөгөө, тайлан
- Хөтөлбөрийн дэд хороо, БУС-ын болон Эрдмийн их сургуулийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлын материал
- Төгсөгчид, ажил олгогчдоос авсан санал асуулгын судалгаа
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлагууд

Шалгуурыг хангасан байдал: : Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны өөрийн онцлог судалгааны аргачлал , судалгаа авах арга техниктэй болсон.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн судалгаа зөвхөн тухайн нэг жилийн түвшинд гаргасан нь хөтөлбрийн үр дүнг бүрэн илэрхийлэхгүй, динамик судалгаа хэрэгтэй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбартаа хүлээн зөвшөөрч байгааг нотлох баримт бичгийн судалгаа гаргадаг болох.
- Мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- Төгсөгчдийн судалгааг улам тодорхой болгон, хөтөлбөрт хамрагдсанаар төгсөгчдийн ажил амьдралд гарсан өөрчлөлт ахиц, төгсөгч ажлын байртай болох хүртлээ хүлээсэн хугацаа өмнөх боловсролын түвшинтэй болон бусад сургуулиудтай харьцуулан олон жилийн динамик үзүүлэлт байдлаар тасралтгүй гаргаж хэвших.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- 2017 онд байгууллагын магадланд орсон ӨҮТ
- Холбогдох судалгааны материал
- Төгсөгчид, ажил олгогчдоос авсан санал асуулгын судалгаа
- Шинжээчдийн хийсэн уулзалт, ярилцлагууд

Шалгуурыг хангасан байдал: : Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Ахисан түвшний сургалт явуулдаг их сургууль болохын хувьд 2018 онд улсдаа анх удаа байгууллагын магадлан итгэмжлэлд орсон.

Анхаарах асуудал:

- Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг зөвхөн хаалттай хэлбэрийн санал асуулгаар тодорхойлох нь хангалтгүй.

Зөвлөмж:

- Мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлэх.
- МУ-ын Дээд боловсролын байгууллагуудын хэмжээнд өөрийн бизнесийн удирдлагын хөтөлбөрийн рейтингээ тогтоох судалгааг ашиглах чиглэл барих.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			Бүх шалгуурыг бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	2			Бүх шалгуурыг бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			Үйл ажиллагааны 3 шалгуураас 2-г бүрэн, 1 шалгуурыг хэсэгчлэн хангасан боловч давуу талууд нь хүчтэй гэж үзсэн
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт		1		Үйл ажиллагааны 5 шалгуураас 3-г хэсэгчлэн, 2 шалгуурыг бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			Үйл ажиллагааны 5 шалгуураас 4-г бүрэн, 1 шалгуурыг хэсэгчлэн хангасан боловч давуу талууд нь хүчтэй гэж
6	Багшийн үйл ажиллагаа	2			Бүх шалгуурыг бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			Бүх шалгуурыг бүрэн хангасан
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол улсын Эрдмийн их сургуулийн Бизнесийн эрдмийн сургуулийн “Бизнесийн удирдлага” E04130101 магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Б. Даваасүрэн

Шинжээчийн багийн гишүүн: Д.Батжаргал

Шинжээчийн багийн гишүүн: Б. Болормаа

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Монгол улсын Эрдмийн их сургууль, Бизнесийн эрдмийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Бизнесийн удирдлага
Хөтөлбөрийн индекс	E04130101
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийг хариуцан явуулж байгаа сургууль, профессорын баг хөтөлбөрийн талаар судалгааны материалыг бүрдүүлэх, үр дүнд нь дүн шинжилгээ хийж хэвших. • Хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцыг тухай бүр баримтжуулан, албажуулж нийтэд хүртээмжтэй хэлбэрээр ашиглах.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн үр шимийг хүртэгч үндсэн 3 хэрэглэгчийнхээ эрэмбэлэгдсэн хэрэгцээ шаардлагад чиглүүлэн зорилго, зорилтоо нарийвчлан тодорхойлж, сайжруулах арга замаа сонгон хэрэгжүүлэх. • Суралцагчийн үнэлгээнд мэдээллийн технологийн боломжийг илүү өргөн хүрээтэй ашиглах, энэ чиглэлд сургалтын удирдлагын мэдээллийн системийн хөгжил шинэчлэлийг чиглүүлэх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> • Хиймэл оюун ухааны лабораторийн үйл ажиллагааг бүх талаар дэмжих • БНХАУ-аас суралцдаг оюутнуудыг шаардлагатай ном эх сурвалжаар хангах бодлого зохицуулалтад түлхүү анхаарах. • Онлайн сургалтын хэрэгцээ нэмэгдэх хандлагатай уялдуулан энэ чиглэлд тодорхой бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Судалгааны их сургуулийн хувьд эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх. • Магистрантуудыг сайн дурын, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог идэвхжүүлэх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа зөвлөгөө өгөх цахим талбараа хөгжүүлэх. • Сургуулийн удирдлагаас ахмад, залуу үеийн багш нарын зохистой тэнцвэрийг хангасан, тогтвортой хөгжлийн хүний нөөцийн бодлого явуулах. • БУ-ын сургууль, профессорын баг судалгааны төсөл хэрэгжүүлэх, тендер шалгаруулалтад тогтмол оролцдог байх. • Хөтөлбөрөөр суралцагчдыг бие даалган суралцуулах үйл явцыг тасралтгүй удирдах багшийн үйл ажиллагааны үр дүн, үр

	өгөөжийг сайжруулах хяналт урамшууллын тогтолцоогоо сайжруулах.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> Дотоод чанарын баталгаажуулалтын судалгааг тогтмол үе шатаар хийж, дүгнэлт шинжилгээг аль болох олон жилийн динамик түвшнээс үндэслэн гаргаж байх. Хөтөлбөрийн дотоод баталгаажуулалтыг хөндлөнгөөс баталгаажуулах үйл явцыг тогтмолжуулах, зөвхөн дотоодын төдийгүй олон улсын түвшний баталгаажуулалтад ойрын жилүүдэд төлөвлөж орох.
ШААРДЛАГА	
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Бизнесийн удирдлага хөтөлбөрт хамаарах аливаа судалгаа, гүйцэтгэсэн ажил, хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр болон дүрэм журмын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх. Багш, оюутнуудын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. Хөтөлбөрт суурилсан төсөв зохиох, санхүүгийн болон санхүүгийн бус үр дүнг хөтөлбөрт суурилж тайлагнадаг байх тогтолцоог бүрдүүлэх.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Заадаг хичээл
1.	Х.Батцэнгэл	Багш	Sc.D, проф.	Судалгааны арга зүй Компанийн үнэ цэнийн удирдлага
2.	Ш.Бат-Эрдэнэ	Багш	Sc.D, проф.	Инновацийн менежмент Төслийн менежмент
3.	С.Будням	Багш	Sc.D, проф.	Орчин үеийн удирдахуйн ухаан
4.	Б.Оюунцэцэг	Багш	Ph.D, проф.	Санхүүгийн менежмент
5.	А.Гэлэгжамц	Багш	Ph.D, проф.	Судалгааны арга зүй Системийн шинжилгээ, стратегийн шийдэл
6.	С.Нармандах	Багш	Ph.D, проф.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн менежмент
7.	Лю Яцүн	Багш		Бизнесийн эрх зүй
8.	С.Чулуунцэцэг	Багш	Ph.D, дэд проф.	Үр дүнд суурилсан хяналтын менежмент

9.	Я.Эрдэнэчимэг	Багш	Ph.D, дэд проф.	Орчин үеийн хүний нөөцийн менежмент Орчин үеийн маркетингийн удирдлага
10.	Д.Мэндбаяр	Багш	Ph.D, дэд проф.	Чанарын удирдлага
11.	Б.Алтанзул	Багш	Ph.D, дэд проф.	Байгууллагын соёл
12.	Т.Бат-Эрдэнэ	Багш	Ph.D	Ногоон бизнес
13.	Ц.Түвшинтөр	Багш	Ph.D, дэд проф.	Байгууллагын мэдээллийн удирдлага, хиймэл оюун ухаан
14.	П.Оюун-Эрдэнэ	Багш	Ph.D	Олон улсын бизнесийн менежмент

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
			Орон нутгийн, гадаад, Дотуур байранд амьдардаг гэх мэт
1.	М.Тэлмэн	1-р курс	Улаанбаатар хот
2.	Т.Солонго	1-р курс	Улаанбаатар хот
3.	Ж.Ундраа	1-р курс	Улаанбаатар хот
4.	Б.Уранчимэг	1-р курс	Улаанбаатар хот
5.	М.Ариунболд	1-р курс	Улаанбаатар хот
6.	Б.Батнавч	1-р курс	Улаанбаатар хот
7.	Б.Энхжаргал	1-р курс	Улаанбаатар хот
8.	Э.Лувсандамчаа	1-р курс	Улаанбаатар хот
9.	Д.Долзодмаа	1-р курс	Улаанбаатар хот
10.	Т.Ууганбаяр	2-р курс	Улаанбаатар хот
11.	Б.Хаш-Эрдэнэ	2-р курс	Улаанбаатар хот
12.	Л.Номинчимэг	2-р курс	Завхан аймаг
13.	Siriguleng	1-р курс	ӨМӨЗО
14.	Aoriqileng	1-р курс	ӨМӨЗО
15.	Haburi	1-р курс	ӨМӨЗО

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал
1.	Э.Ундрах	Хурд ХХК-ийн Бодлого, төлөвлөлийн газрын дарга
2.	н.Мөнх-Эрдэнэ	Транс банкны салбарын захирал
3.	н.Батдорж	Өвөрхангай аймгийн "ДШЛ" компанийн захирал
4.	н.Отгончимэг	Юнитакс консалтинг ХХК-ийн захирал
5.	П.Оюун-Эрдэнэ	Монгол Өмгөөлөгч ХНН гадаад харилцааны албаны дарга
6.	Т.Шинэцэрэг	Албан журмын даатгагчдын холбоо, мэдээллийн сангийн дарга

7.	И.Басхүү	“Басхүү имплант” эмнэлэгийн захирал
8.	Д.Эхбаяр	Эс-Жи-Эм-Ди Аудит ХХК-ийн захирал
9.	Ж.Хишигжаргал	Нэг бүс нэг зам ОУ-ын судалгааны академи ТББ-ын тэргүүн
10.	Ш.Хишигсүрэн	Соён гэгээрүүлэгч ТВ-ийн захирал
11.	Г.Бат-Эрдэнэ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Тамгийн газрын дарга
12.	Ч.Гэрэлмаа	Скилл ап онлайн сургалтын флатформын дэд захирал
13.	Ц. Одгэрэл	Орхон аймгийн ЕБ-ын 7-р сургууль захирал
14.	Б. Эрдэнэцэцэг	Өмнөговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага , албан тушаал
1.	Ч.Живзүнпагма	2012	Барилгын коллежид нийгмийн ажилтан
2.	Б.Амармэнд	2016	Unitel группд хүний нөөц
3.	Н.Есүхэн	2017	Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны удирдах зөвлөлийн гишүүн
4.	С.Батжаргал	2017	Хийморьт найман шарга ББСБ, захирал
5.	С.Уянга	2018	Хувиараа бизнес эрхлэгч
6.	Д.Атарбаясгалан	2018	Бульдорс Мон ХХК захирал
7.	Б.Энх-Амгалан	2018	Билэгт дөлгөөн ХХК гүйцэтгэх захирал
8.	Б.Сайнсанаа	2019	АПУ Трейдинг ХХК, Импортын худалдааны маркетинг борлуулалтын албаны дарга
9.	Бао Хiao Long	2019	Хувиараа бизнес эрхлэгч
10.	Т.Өлзийсүрэн	2019	Басхүү Имплант Клиник Гүйцэтгэх захирал
11.	Wang Baigala	2019	БНХАУ-ын эрчим хүчний группын Багануур Пауэр ХХК-д Ерөнхий албаны хэлтсийн нарийн бичиг
12.	О.Мөнхтөр	2020	Үндэсний хөгжлийн газар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга
13.	А.Анххөтөл	2020	Хөтөлийн цемент Шохой ХХК мэдээллийн ажилтан
14.	Б.Сэлэнгээ	2018	Масс эженси ххк, захирал

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



**МОНГОЛ УЛСЫН ЭРДМИЙН
ИХ СУРГУУЛЬ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар
Хороо, Бага тойруу, Утас/Факс: (976) 7600-2010
Цахим шуудан: info@gradedu.mn, www.gradedu.mn

2020.06.04 № 1/154
танай _____ -ны № _____ -т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

Санал хүргүүлэх тухай

Тус сургуулийн "Бизнесийн удирдлага" E04130101 магистрын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчдийн тайлантай танилцлаа.

Шинэ төрлийн коронавирус (COVID-19) цар тахлын хорио, цээрийн дэглэмийн үед Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс баталсан дүрэм, журам, тогтоосон шалгуур, шаардлага болон Монгол Улсын Эрүүл Мэндийн яам, холбогдох мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж шийдвэрийг баримтлан 2020 оны 5 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Бизнесийн удирдлага магистрын хөтөлбөрт БМИҮЗ-ийн шинжээчийн баг ажилласан. Шинжээчийн багийн тайланд шалгуурын "анхаарах асуудал", "зөвлөмж" (шалгуур 1.1, 2.1, 2.2, 2.3, 3.2, 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5, 5.2, 5.3, 6.2, 6.3, 7.2)-ийн зарим хэсэгтэй тус сургуулийн өөрийн үнэлгээний баг санал нийлэхгүй байгаа тул тайланд дахин нягталж үзэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ч. ЗЭГИЙМАА

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2020.06.12
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилнэ	5 жил

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) 2020.06.16
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилнэ	5 жил

Зөвлөмж /Recommendations/